

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

		Улаанбаатар хот	
Д/д	Зорилго	Хэрэгжилт	Зарцуулсан хөрөнгө
1	2	3	4
Нэг. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх			
1.1.	<p>АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;</p>	<p>Албан тушаалтнуудын 2021 оны Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг бүртгэх, хүлээн авах үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газраас улсын хэмжээнд зохион байгуулсан хугацаанд Мэдүүлэг гаргагч нарт зориулсан мэдээлэл, видео сурталчилгааг https://www.youtube.com/watch?v=iBU7wgKFs-o, https://www.youtube.com/watch?v=ELmmJ5-svPE хаягаар 2022.02.15-ны дотор ХАСХОМ гаргах зааварчилгааг Комиссын цахим хуудас болон пейж хуудсанд байршуулж, мэдээллээр хангасан. Түүнчлэн Комиссын цахим хуудсанд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн ном гарын авлага, авлигын эсрэг шторкууд, АТГ-ын мэдээлэл зэрэг холбогдох мэдээлэл, линкийг байршуулж, албан хаагчдад мэдээлэл өгч ажилласан.</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй харах нөхцөл боломжоор хангасан.</p>
1.2.	<p>Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлог, тохируулан зохион байгуулах;</p>	<p>Хэрэгжилт 100%</p> <p>Авлигатай Тэмцэх газраас улсын хэмжээнд зохион байгуулж байгаа “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд “Авлигатай тэмцэх газар” пейж хуудас, “АТГ-ын Олон нийтийн төв” фэйсбүүк пейж хуудсыг комиссын нийт албан хаагчдад нэгдэх, дагах, өөрсдийн пейж хаягаар дамжуулан бусдад түгээх, сурталчлах уриалгыг NHRCM пейж группд оруулж, шинээр 12 албан хаагч нэгдсэн байна.</p>	<p>Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг таниулах чиглэлээр сурталчилсан.</p>
Хоёр. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулсан сургалтад хамруулах			

2.1.	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх	Авлигатай Тэмцэх газраас шинээр томилогдсон эрх бүхий албан хаагчдад зориулсан цахим сургалтад комиссын эрх бүхий албан хаагч хамрагдаж, шинэ мэдээлэл, мэдлэг олж авсан. Үүний хүрээнд 2021 оны ХАСХОМ гаргахтай холбогдуулан мэдүүлгээ хэрхэн үнэн зөв мэдүүлэх талаар төв болон орон нутгийн 26 мэдүүлэг гаргагчдад цахим сургалт зохион байгуулсан. Мөн 2021 онд шинээр томилогдсон, урьд нь ХАСХОМ гаргаж байгаагүй 3 мэдүүлэг гаргагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгсөн.	-	Албан хаагчид мэдүүлгээ хуулийн хугацаанд үнэн зөв гаргасан.
2.2.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнаж байх	Баянхонгор аймгийн ЗДТГ, ТАЗ-ийн Баянхонгор аймаг дахь салбар зөвлөл, Цагдаагийн газар хамтран 2022.06.29-ний өдөр зохион байгуулсан төрийн алба хаагчдын сахилга, хариуцлагын зөвлөгөөнд ХЗҮК-ын гишүүн Х.Мөнхзул, Комиссын Тамгын газрын холбогдох албан тушаалтнууд оролцож төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа хандлагаас хамаарч хүний эрх зөрчиж байгаа асуудлыг анхаарч, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагыг сайжруулах, хэн байхаас үл хамаарч хүн бүртэй хүний ёсоор тэгш хүндэтгэлтэй, шударга хандаж, бусдыг аливаа хэлбэрээр хавчин гадуурхахгүй хүний эрхэд суурилсан хандлагаар төрийн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах талаар мэдээлэл хийв. Зөвлөгөөнд 250 гаруй төрийн албан хаагч хамрагдсан.	-	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн үйл ажиллагааны онцлогтой нийцүүлэн сурталчилсан.
Гурав. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх				
3.1.	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ	2021 оны Хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчлэн гаргаж байгаа албан хаагчдын цахим мэдүүлгийн бүрдүүлэлтэд хяналт тавьж, арга зүйн заавар, зөвлөгөө өгч ажилласан. Нийт 36 мэдүүлэг гаргагч хуулийн хугацаанд мэдүүлгээ ирүүлж, баталгаажуулсан. 2021 оны тайланг ХАСХОМ-1, ХАСХОМ-2 маягаар гаргаж АТГ-т албан бичгээр хүргэсэн.	-	Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангагдсан.

		<p>Гэрээ байгуулах асуудлаар гаргасан ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тухай 67 мэдэгдэл тайлбарыг meduileg.iaac.mn цахим системд бүртгэсэн. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 39 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт албан бичгээр хүргүүлж, ирүүлсэн хариуг үндэслэн 24 иргэнийг ажилд томилж, томилогдсоноос хойш 30 хоног дотор мэдүүлгийг гаргуулж, хянаж баталгаажуулсан.</p> <p>Шинээр томилогдсон Хүний эрхийн Үндэсний Комиссын 2 гишүүний тогтоол болон хувийн мэдээллийг Авлигатай Тэмцэх газрын хариуцсан ажилтанд цахимаар илгээж, 30 хоногийн дотор мэдүүлэг гаргах эрх нээлгэж, заавар зөвлөмж өгч ажилласан.</p>		
3.2.	<p>Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга, уриа, аянд нэгдэх</p>	<p>Хэрэгжилт 100%</p> <p>Хүний эрхийн Үндэсний комиссоос төрийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээ нь хүнд суртал, чирэгдлээс болж хүний эрх зөрчигдөж, авлига хаана байна тэнд хүний эрх зөрчигдөж байна гэсэн асуудлаар Авлигатай Тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн төвтэй 2022.03.22-ны өдөр уулзалт зохион байгуулж хамтран ажиллахаар шийдвэрлэсэн. Уулзалтаас гарсан саналыг Хүний эрхийн Үндэсний Комиссын Тамгын газрын Гомдол хяналт шалгалтын хэлтэс үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.</p>		<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжиж холбогдох байгууллагатай хамтран ажилласан.</p>
3.3.	<p>Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх</p>	<p>Хэрэгжилт 100%</p> <p>Байгууллагын хэмжээнд эхний хагас жилийн байдлаар нийт 67 гэрээ байгуулагдсан бөгөөд гэрээ бүрд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбарыг Тамгын газрын дарга болон гэрээ байгуулсан хэлтсийн дарга нар тухай бүр гаргасныг meduileg.iaac.mn цахим системд тайлагнасан. Төрийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тендерийн үнэлгээний багт ажиллаж байгаа 3 иргэн, 3 албан хаагчаас ашиг сонирхолгүй мэдэгдэл, тайлбар ирүүлсэн.</p>		<p>Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн.</p>

3.4.	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх/</p>	<p>Хүний эрхийн зөрчлийн талаар иргэдээс ирүүлэх гомдол мэдээллийг 70000222 тусгай дугаарын утсаар хүлээн авч байна. Түүнчлэн Хүний эрхийн Үндэсний Комиссын цахим хуудас /www.nhrctm.gov.mn/ болон пэйж хуудсаар өргөдөл хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх тусгай цэс ажиллуулж, хариуцсан ажилтныг үүрэгжүүлэн, тухай бүрд шуурхай, бүртгэж холбогдох ажилтанд шилжүүлж, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, холбогдох иргэнд албан бичгээр болон утсаар, биечлэн байдлаар шийдвэрлэсэн хариуг мэдэгдсэн.</p> <p>Төрийн үйлчилгээг иргэн бүрд нээлттэй, тэгш, хүртээмжтэй хүргэх, мэдээллээр хангах, иргэдийн санал хүсэлтийг байнга хүлээн авч шийдвэрлэх, үйл ажиллагаандаа тусгах, төр иргэн хоорондын харилцааг зохицуулах, хүний эрхийн чиглэлээр иргэдээс иргэдээс асуумж, санал хүсэлт, мэдээлэл дэлгэрэнгүй авах зорилгоор байгууллагын суурин утсыг "CALLPRO" үйлчилгээнд шилжүүлсэн.</p> <p>Хүний эрхийн асуудлаар нийт 1127 иргэнд 24604 минутын зөвлөгөө өгсөн байна. Үүнээс Гомдол, мэдээлэл, шалгах хэлтсийн ажилтнууд 276 иргэнд 3183 минутын (утсаар 167, биечлэн 109), орон нутаг дахь ажилтнууд нийт 851 иргэнд 21417 минутын (утсаар 168, биечлэн 678, цахимаар 5) зөвлөгөө өгсөн байна.</p> <p>Тайлант хугацаанд нийт 784 гомдол, мэдээллийг хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэсэн байгаа бөгөөд 80 гомдол, мэдээлэл нь ажиллагаанд байна.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	-	Иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг шуурхай хүлээн авах, шийдвэрлэх боломжийг хангасан.
Зургаа. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах				
6.1.	<p>Байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, цахим хуудсыг шинэчлэх өргөжүүлэх</p>	<p>2022 оны байдлаар ХЭҮК-ын байранд биечлэн ирсэн 5, фэйсбүүк хуудсаар дамжуулан 5, утсаар 6 нийт 16 иргэнд Комиссын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл өгсөн. Үүнд:Текст, зурагт хуудас хэлбэрээр цаг үеийн мэдээ, мэдээллийг хүргэж, цахим хуудаст орсон мэдээллийг фэйсбүүк, твиттер хуудсаар иргэд олон нийтэд хүргэсэн. Үүнд:</p>	-	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан.

	<p>- “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл” файлаар авах;Цэргийн алба хаагчдын дүрмийн бус харилцаанд хийсэн судалгааг хаанаас авах;</p> <p>- Ажлын байрны бэлгийн дарамтын талаарх судалгаа хэвлэмээр авах</p> <p>- Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд оноож буй ял шийтгэлийн нөхцөл байдлын судалгаа байгаа эсэхийг лавлаж;</p> <p>- Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой судалгаа байгаа юу?</p> <p>- Хүн худалдаалах гэмт хэргийн статистик тоог хаанаас авч болох вэ?</p> <p>- Танайд гомдол гаргахын тулд заавал биечлэн очих шаардлагатай юу?</p> <p>- Өсвөр насны ЕБС-ийн сурагчдын дунд үе тэнгийн дээрэлхэлт их гарч байгаа учраас хаана, хэнд гомдол гаргах вэ?</p>	
	<p>Хэрэгжилт 100%</p> <p>Жилийн эцсийн байдлаар удирдах 1, гүйцэтгэх 6 албан тушаалын сул орон тооны захиалгын дагуу нийтэд сонгон шалгаруулалт зарлаж 2 ажлын байр нөхөгдсөн. 4 албан тушаалд албан тушаалын тусгай шаардлага хангаагүй тул нөхөгдөөгүй болно.</p> <p>Ажлаас чөлөөлөгдсөн 2, шинээр томилогдсон 7 албан хаагчийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд шинэчлэн оруулсан.</p> <p>Мэдээллийн технологийн ажилтны сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас болон пейж хуудсаар 2022.04.20-04.28-ны өдрүүдэд нийтэд ил тод байршуулж мэдээлсэн.</p> <p>Байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл байгуулсан тухай Тамгын газрын даргын 2022.05.12-ны өдрийн А/29 дүгээр тушаалыг байршуулсан.</p> <p>Сар бүр Шилэн дансны цахим хуудсанд Тамгын газрын бүтэц орон тооны мэдээллийг тухай бүрт оруулсан. Ашиг сонирхлын зөрчил үүсээгүй тухай 20 мэдэгдэл оруулсан.</p>	<p>Хүний нөөцийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан.</p>

	<p>хэмнэлтийн тооцоог хийж, хэмнэлт хийгдэх ангиллаас төсвийн хуваарьт санхүүжилттэй ангилал руу Сангийн яамнаас зөвшөөрөл авч шилжүүлэн зарцуулсан.</p> <p>Хэрэгжилт 100%</p>		
<p>Долоо. Төрийн албан хаагчийн ёс зүй, харьцаа хандлагыг дээшлүүлэх</p>			
<p>7.1.</p>	<p>Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилон, дэвшүүлэх</p>	<p>Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын 2022.06.15-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2022.07.07-ны өдрийн 469,470, 541 дүгээр тогтоолын дагуу Тамгын газрын даргын 2022.07.21-ний А/56 дугаар тушаалаар нийт удирдах 8, гүйцэтгэх 27 буюу 34 албан тушаалын тодорхойлолтыг батлан, мөрдөж ажиллаж байна.</p> <p>Төрийн албаны мерит зарчмыг хангах зорилгоор албан хаагчийн мэргэжлийн шаардлагыг нэгжийн даргын шаардлагатай нийцүүлэх, хуульд заасан мэргэшлийн шаардлагаас гадна тухайн албан тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах гадаад хэлний түвшин, хууль эрх зүйн мэргэжлээр ажилласан байх шаардлагыг нэмж тусгасан.</p> <p>Тайлант хугацаанд шатлан дэвших зарчмын дагуу албан тушаалын тусгай шаардлага хангасан албан хаагчийг дэс түшмэлээс ахлах түшмэл, ахлах түшмэлээс тэргүүн түшмэлийн ангилалд байгууллага дотроо 13 албан хаагчийг шатлан дэвшүүлж томилсон.</p> <p>Хэрэгжилт 100%</p>	<p>Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан.</p>
<p>7.2.</p>	<p>Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>Тамгын газрын даргын 2022.05.12-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл байгуулж, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллав. Байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан эсэх асуудлаар 10 сард 2 удаа хуралдаж, ёс зүйн зөрчил гаргаагүй гэж дүгнэсэн.</p> <p>Төрийн албан хаагчийн сахилга бат, ёс зүй, ажлын гүйцэтгэл, чанар, хариуцлагыг сайжруулах чиглэлээр удирдах албан тушаалтнаас ирүүлсэн саналыг үндэслэн</p>	<p>Төрийн албан ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, дотоод хяналтыг сайжруулсан.</p>

	<p>Говь-Алтай аймаг дахь ахлах мэргэжилтэн А.Наранбаатарт хяналт шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох асуудлаар Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлж ажилласан.</p> <p>Комиссын албан хаагчид болон орон нутаг дахь албан хаагчдад хуульд заасан үүрэг, хариуцлага, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт чиг үүргийг чанартай гүйцэтгэх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүр биелүүлж, ёс зүйтэй ажиллах талаар Тамгын газрын 2 удаагийн хурлаар удирдлагаас үүрэг, чиглэл өгсөн.</p>	
Нийт-100% Хэрэгжилт 100%		

ХЯНАСАН:

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ



О.НАРАНБАЯР

(Handwritten signature)